# НИЙСЛЭЛИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
# НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар х

| | Зорилт | Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал | Суурь түвшин | | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Зорилтот түвшин | Санхүүжилт сая.төг | Төсвийн гүйцэтгэл | Хэрэгжилтийн явц |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | он | түвшин | | | | | | |
| 1 | НХТЖҮ Ч-6.2.1 | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан түлшний нөөц бүрдүүлэх, борлуулалтын цэгийн тоог нэмэгдүүлж, түгээх, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих | НАОБТГ | НТ | 2023 | 670,000 | Тээвэрлэсэн түлшний хэмжээ | тн | 670,000 | 39,800.00 | 9,400.00 | Нийслэлийн 7 дүүргийн 197 хорооны гэр хорооллын 171,976 айл өрхийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/141 дүгээр захирамжийг үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар гэрээт 30 тээврийн компани Зүүн болон Баруун бүсийн үйлдвэрээс эцсийн борлуулалтын цэг, агуулахад 210,375.5 тонн сайжруулсан түлш тээвэрлэсэн байна. Тээвэрлэлтийн санхүүжилтэд 9,4 тэрбум төгрөг олгосон. |
| 2 | | | НАОБТГ | - | 2023 | 120,000 | Нөөцлөлт | тн | 120,000 | - | - | Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/140 дүгээр захирамжаар өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор Нийслэлийн өмчийн 4, түрээсийн 26, нийт 30-н агуулахад сайжруулсан түлш нөөцлөн хадгалалт, борлуултад хяналт тавин ажилласан. 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Нийслэлийн өмчийн 4-н агуулах 302 тонн шахмал түлшний нөөцтэй байна. |
| 3 | | | НАОБТГ | - | 2023 | 504,900 | Борлуулалт | тн | 504,000 | - | - | Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/142 дугаар захирамжийг үндэслэн агаарын чанарыг сайжруулах бүсэд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд сайжруулсан шахмал түлшний |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | 441 борлуулалтын цэгт 236,714 тонн түлш хэрэглэгчдэд нийлүүлж, нөөц бүрдүүлэлт, татан авалт, борлуулалтад хяналт тавин ажиллаж байна. | |
| 284 | Агаарын бохирдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор уршиг, түүнийг бууруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | НАОБТГ | НТ | 2023 | 14 | Зохион байгуулсан арга хэмжээ | тоо | 16 | 170 | - | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай хамтран Агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдийг цахилгаан болон бүх төрлийн хийн халаагуурт үе шаттай шилжүүлэхтэй холбоотойгоор ногоон бүсэд хамаарах 51,080 айл өрхийн гэр, байшингийн дулаалга ажлын хүрээнд "Дулаан байшин" амины орон сууцны нээлттэй өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 4-7-ны хооронд Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, нийт 12,000 гаруй иргэд олон нийтэд дулаалгын талаар танилцуулга мэдээлэл, 12000 гаруй ширхэг гарын авлага хүргэн ажилласан болно. | 100 |
| | | НАОБТГ | - | 2023 | 2 | Зохион байгуулсан сургалт | тоо | 2 | - | - | Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдийн халаалтыг цахилгаан болон бүх төрлийн хийн түлшинд шилжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын А/482 дугаар захирамжийн дагуу "Гэр, байшингийн дулаалгын дэлгэрэнгүй судалгааг хийж гүйцэтгэх албан хаагчдыг чадавхжуулах" сургалтыг Баянгол, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн 35 хорооны 474 хэсгийн ахлагч нарыг | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хамруулан зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, мэдээллээр хангаж ажилласан. | |
| | | НАОБТГ | - | 2023 | 182,100 | Тараасан зөвлөмж | тоо | 199,860 | - | - | Тус газар нь shuud.mn, news.mn, medee.mn, chig.mn, blood.mn, Үндэсний хөгжлийг дэмжих сэтгүүлчдийн зөвлөл НҮБТББ болон сайтуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан байгууллагын албан ёсны пэйж хуудсаар дамжуулан улаанбаатар хотын агаарын чанарын индексийн нийт 35 удаагийн мэдээ, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, зөвлөмж мэдээ, мэдээллийн талаар 20 инфографик зурагт хуудас, анэймэшн хэлбэрээр бэлтгэсэн 6 видео, нийтлэл 4, сайн туршлагын талаар богино хэмжээний 1 видео контентыг тус тус бэлтгэн 78,000 гаруй иргэд олон нийтэд хүргэж ажилласан байна. Мөн MGL FM радиотой хамтран 2025.02.13-03.06 өдрийг хүртэл хугацаанд шууд эфирээр дамжуулан угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | мэдээ мэдээллийг нийт 300,000 нийт 378000 гаруй иргэд, олон нийтэд угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулж ажилласан байна.<br><br>2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр батлагдсан "Хэвлэл цахим сувгаар угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах" ажлын төлөвлөгөөний хүрээнд Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар шторк, богино хэмжээний рийлс болон инфографик зурагт хуудсыг нийслэлийн 7 дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран дүүргүүдийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах тасаг, хороодын ажлын албаны групп хуудасд байршуулж нийт 15000 гаруй иргэдэд хүрсэн байна. | |
| Таван толгой түлш ХХК-ийн үйлдвэрлэсэн сайжруулсан | НАОБТГ | НТ | 2023 | 37 | Шинжилгээнд хамруулсан дээжийн тоо | тоо | 37 | 5 | - | Урьдчилан сэргийлэх 01/09 дугаартай удирдамжийн хүрээнд "Таван толгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал | 100 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шахмал түлш, түүний түүхий эдээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх | | | | | | | | | | түлшний чанар стандартын шаардлага хангаж буй байдалд тогтмол хяналт шалгалтыг хийж байна. 2025 оны 01 дүгээр сарын 03-наас 05 дугаар сарын 29-ны өдрийн байдлаар Төв, Зүүн Баруун бүсийн үйлдвэрийн үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлшний 14, мидлингийн 3, барьцалдуулагчийн 1 дээж нийт 18 дээжид Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газрын төв лаборатори, Геологийн судалгаа шинжилгээний төв ТӨҮГ, Хими, химийн технологийн хүрээлэнгийн итгэмжлэгдсэн лабораторид тус тус техникийн шинжилгээнд хамруулсан. Лабораторийн шинжилгээний сорилын дүнгээр тус дээжүүд MNS5679:2022 "Сайжруулсан хатуу түлш. Техникийн ерөнхий шаардлага" стандартыг хангасан. | |
| 6 | | Автозамын хөдөлгөөнд оролцож буй дизель хөдөлгүүрт нийтийн болон ачаа тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт хийх | НАОБТГ | НТ | 2023 | 450 | Тээврийн хэрэгсэл | тоо | 450 | 5 | - | Автозамын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн хаягдал утааны болон тээврийн хэрэгслээс үүдэлтэй орчны бохирдлын агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалтыг хүйтний улиралд хийх боломжгүй ба шалгалтын явцад автозамын ачаалал үүсгэх тул жил бүр тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачаалал бага буюу 8 дугаар сард хийж гүйцэтгэдэг.<br>Тус шалгалтыг Нийслэлийн тээврийн цагдаагийн албатай хамтран төлөвлөгөөт бус шалгалтын удирдамжийн хүрээнд 2025 оны гуравдугаар улирал буюу 08 дугаар сард хийж гүйцэтгэнэ. | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 87 | НХТЖҮ Ч-6.2.1 | Агаар, орчны чанарт нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын орчны чанарт хэмжилт хийх, үнэлгээ, зөвлөмж өгөх | НАОБТГ | НТ | 2023 | 30 | Хэмжилт хийсэн тоо | тоо | 30 | 50 | 0 | Нийслэлийн 9 дүүргийн иргэн аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийн хооронд нийт орчны агаарын чанарын 10 хэмжилт хийснээс Орчны агаарын чанарын MNS4585:2016 стандартыг бүгд хангасан байна. Судалгааны зорилгоор 4 аж ахуйн нэгжийн 17 цэгт харьцуулсан хэмжилт хийж дүнг боловсруулан ажилласан. | 100 |
| 88 | | Уурын болон 100 кВт-аас дээш ба доош хүчин чадалтай усан халаалтын зууханд хэмжилт хийх | НАОБТГ | НТ | 2023 | 36 | Хэмжилт хийсэн зуух | тоо | 50 | 100 | 0 | Уурын болон усан халаалтын зуух эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 27-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 26 зууханд хэмжилт хийж ажилласан. Хэмжилтийн дүнг Монгол Улсын MNS 5043:2016, MNS 5919:2009, стандартад заасан үзүүлэлттэй харьцуулан боловсруулахад стандартын шаардлага хангасан 13, хангаагүй 13 зуух байна. | 100 |
| 9 | | Агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нийслэл дэх нэгжийн тасралтгүй ажиллагааг хангах | НАОБТГ | НТ | 2023 | 6 | Харуулын цэг | тоо | 6 | 100 | 0 | Суурин харуулын хэвийн үйл ажиллагааг хангаж сар бүр стандарт хийн тохируулга хийх, 7 хоног бүр төхөөрөмжүүдийн хэвийн үйл ажиллагааг шалгаж фильтер солих засвар үйлчилгээ хийж ажиллаж байна. Мөн өнгөрсөн 24 цаг болон өнгөрсөн 7 хоногийн дата мэдээг боловсруулан ЦУОШГ-т хүргүүлэн ажилласан..<br>Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг өмнөх онуудын мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 53 мкг/м3 буюу 16%-иар, азотын давхар исэл ($NO_2$) нь 47 мкг/м3-ээр буюу 11%-иар, хүхэрлэг хий ($SO_2$) нь 68 мкг/м3-ээр буюу 16%-иар тус тус бага. Харин | 100 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | PM10 тоосонцор нь 106 мкг/м3-ээр буюу 5%-иар их байна. | |
| 90 | | Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лаборатори шинээр байгуулах бэлтгэл хангах | НАОБТГ | НТ | 2023 | - | Зураг төсөв | тоо | 1 | 300 | - | Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лабораторийн барилгыг Хан-Уул дүүргийн 10-р хороонд барихаар төлөвлөсөн. НИТХ-ын 2025.04.25-ны өдрийн 25/50 дугаар төсвийн өөрчлөлт оруулах тухай тогтоолоор тус төсөл арга хэмжээг тухайн онд санхүүжүүлэх төсвийг хассан тул ажлын хэрэгжилт хойшилсон. | - |
| 1 | | Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, засварлах | НАОБТГ | НТ | 2023 | - | Тоног төхөөрөмж | тоо | 10 | 800 | - | Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 11-ний А/165 дугаар эрх шилжүүлэх тухай захирамжийн хүрээнд 51,000 ширхэг алсын зайн дамжуулагчтай угаарын хийн мэдрэгчийн худалдан авалтыг зохион байгуулахаар Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/10 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн хүрээнд зохион байгуулан ажилласан. “Алсын зайн дамжуулагчтай угаарын хий мэдрэгч” төхөөрөмжийн нийлүүлэгчээр “ИНТЕЛЛГЕНТ ТЕХНОЛОГИ”ХХК нь 7,650,000,000.0 (долоон тэрбум зургаан зуун тавин сая) төгрөгийн санал ирүүлж, 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/165-1 дугаартай гэрээ байгуулсан. 51,000 ширхэг төхөөрөмжийг дагалдах хэрэгслийн хамт актаар хүлээн авч, гүйцэтгэгчийн ажлыг дүгнэж, “Түлш Хэрэглэгчдэд үйлчлэх төв” ОНӨААТҮГ-т хүлээлгэн өгч Агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхүүдэд суурилуулж байна.<br>Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмжийг | 100 |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25 -ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/547 тоот захирамжаар “Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмж” худалдан авах 1,096.0 сая төгрөгийн санхүүжилттэй 4 төсөл арга хэмжээний 3 ажлыг Худалдан авах ажиллагааны газар, 1 ажлыг Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх зохион байгуулж байна. Худалдан авах ажиллагааны газар 3 багц ажлын хүрээнд тендер сонгон шалгаруулах зарыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд (www.tender.gov.mn) байршуулж тендерийн нээлтийг 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр нээж үнэлгээний хорооны хурлаар хэлэлцсэн.<br>Багц-1: Дуу чимээ, үнэрийн хэмжээг тодорхойлох багаж тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг дахин зарлаж 2025 оны 06 сарын 23-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нээсэн.<br>Багц-2: Автомашины хаягдал утааны хийн хэмжилт хийх багаж тоног | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон.<br>Багц-3: Орчны бохирдлыг хэмжих суурин төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон.<br>Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газар 4 дэх заалтын хүрээнд Газрын даргын 2025 оны 04 сарын 28-ны өдрийн А/49 тоот тушаалаар "Тоног төхөөрөмжийн тохируулга хийх стандарт хий" нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан ажилласан. Тендер сонгон шалгаруулах зарыг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд (www.tender.gov.mn) байршуулан 2025 оны 05 сарын 12-ны өдөр нээж үнэлгээний хорооны хурлаар хэлэлцэж "Тоног төхөөрөмжийн тохируулга хийх стандарт хий" нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон. | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | орон сууцжуулалтын яамтай хамтран Агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдийг цахилгаан болон бүх төрлийн хийн халаагуурт үе шаттай шилжүүлэхтэй холбоотойгоор ногоон бүсэд хамаарах 51,080 айл өрхийн гэр, байшингийн дулаалга ажлын хүрээнд "Дулаан байшин" амины орон сууцны нээлттэй өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 4-7-ны хооронд Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, нийт 12,000 гаруй иргэд олон нийтэд дулаалгын талаар танилцуулга мэдээлэл, 12000 гаруй ширхэг гарын авлага хүргэн ажилласан болно. | | |
| | | | | | | | | | | | Дундаж хувь | 95% | |

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.МӨНХБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Г.АРИУНТУНГАЛАГ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ХАМТЫН
АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.ДӨЛГӨӨН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТӨВӨЛЛӨГӨӨ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН О.МӨНГӨН-ЭРДЭНЭ